



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/201

Хажуу шлөс үс

Техникийн хяналтын үзлэг, тээврийн  
хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 17 дугаар зүйлийн 17.1, 17.1.1, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/174 дүгээр тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, албан татвар, төлбөр хураалт, техникийн хяналтын үзлэгийг 2023 оны 05 дугаар сарын 02-04-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, албан татвар, төлбөр хураах, техникийн хяналтын үзлэг тооллого явуулах комиссыг хавсралтаар баталсугай.

3. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлд хамрагдалт, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар орон нутгийн зам ашигласны төлөлт, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан байдал хяналт, шалгалт хийж, зөрчлийг тухай бүрд арилгуулж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), Ажлын хэсгийн ахлагч (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

4. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийг шинэчилсэн бүртгэл татвар хураалтын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж ажилласан дүн мэдээг улирал тутам танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн А/39 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  ТАРИУНАА



482301020

Засаг даргын 2022 оны 24...  
сарын 28-ний өдрийн 4/21...  
тоот захирамжийн хавсралт



Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн шинэчилсэн бүртгэл,  
албан татвар, төлбөр хураах, техникийн хяналтын үзлэг тооллого  
явуулах комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга	Н.Ганбат (Санхүү албаны дарга)
Нарийн бичгийн дарга	Д.Алтансаргай (Татварын улсын байцаагч)
Гишүүдэд	Э.Уранбилэг (Сангийн нягтлан бодогч)
	Б.Гүнсэнтүг (1 дүгээр багийн Засаг дарга)
	Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Даваасүрэн (3 дугаар багийн Засаг дарга)
	Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)
	Э.Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч)
	Б.Наранбаатар (Хэсгийн цагдаа)